

Монголд ЦӨМИЙН ХАЯГДАЛ булшлах асуудлын ТОЙМ

(Явуулын хүнд улс орныхоо ирээдүйг даатгаж сууна даа бид...)

2011-05-20

Амарлин

Оршил буюу өнгөрснийг сануулахуй

Өнгөрсөн арваад хоногийн туршид Монголын нутагт цөмийн хаягдал булшлах тухай мэдээ олны анхаарлыг татсан халуухан сэдвүүдийн нэг байлаа. Хэд хоног дээр дооргүй үймж, хэвлэлийн хурал, баримтат нэвтрүүлэг, эсэргүүцлийн жагсаалтай өнгөрүүлээ. Тэгвэл энэ асуудал хэзээ эхэлсэн, хэрхэн өрнөсөн талаар хүмүүст цогц ойлголт өгөхөөр товч тойм бэлдсэнийг уншиж танилцана уу.

I. ЭХНИЙ ҮЕ

Асуудал анх үүссэн үе нь *Global Seciruty Newswire* сэтгүүлд 2011 оны 3 сарын 30-нд гарсан нийтлэлийг орчуулж news.mn дээр тавьсантай давхацна. Тус нийтлэлийг бичсэн Америк сурвалжлагч нь Олон Улсын Цөмийн Бодлогын хурлаас сурвалжлага хийсэн юм билээ. Ингэхдээ АНУ-ын Эрчим хүчний Яамны хэлтсийн дарга хариуцлагатай албан тушаалтан **Монголд олон улсын цөмийн хаягдлын төв байгуулж, Солонгос, Тайвань гэх мэт АНУ-аас цөмийн түлшээ авдаг улс орнуудын хаягдал түлшийг булах талаар ярилцаж байгаа** гэж эргэлзэх зүйлгүйгээр мэдэгдсэнийг иш татсан аж. Албаны хүний хэлсэн үгийг бататгах хурлын ярианы аудио бичлэг, хэлэлцүүлгийн протокол нь тус Олон Улсын Хурлыг зохион байгуулсан Карнегийн Сангийн цахим хуудсан дээр тавьсан байлаа.

http://www.globalsecuritynewswire.org/gsn/nw_20110330_8553.php

<http://www.ireport.mn/read/1891.shtml>

<http://economy.news.mn/content/61059.shtml>

<http://carnegieendowment.org/events/?fa=viewSubEvent&id=43479>

Хэвлэл мэдээллийнхэн хэрхэн хүлээж авав?

Монголын сэтгүүлчид асуудалд хойрго хандаж, эхний шатны сорилд бүдэрсэн. Угтаа бол нарийн судалгаа хийж, олон жилийн туршид ярьж буй эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ур чадвараа нийтэд дэлгэн үзүүлэх бодитой боломж тэдэнд байсан юм. Улс эх орны аюулгүй байдал, ирээдүйтэй холбоотой ийм чухал мэдээллийг иргэн бүр, тэр дундаа хэвлэл мэдээллийнхэн онцгой анхаарч, өчүүхэн ч атугай эргэлзээ төрвөөс нягтлан судалж үнэн мөнийг эрэлхийлмээр. Интернэт өдөр тутмын хэрэглээ болсон өнөө цагт мэдээллийг эрж хайх, нотлох ч түвэггүй болсон баймаар.

Харамсалтай нь асуудлын мөрөөр цөөн хэдэн нийтлэл гарсан нь эргэлзсэн өнгө аястай, орчуулгын бага сага зассан хувилбарууд байсан ба ганц нэг албаны хүнтэй холбогдож тодруулах оролдлого хийсэн ч төдийлэн үр дүнтэй байж чадалгүй мухарджээ. Түүнчлэн ганц нэг нийтлэл нь бодит үнэнийг зориудаар мушгин гуйвуулсан, захиалгат шинжтэй байсныг өгүүлсүү.

http://www.dailynews.mn/?vfile=7&vmet_id=18274&vmet_main=6470&vdate=&vl=archive

<http://www.mongolnews.mn/i/17774>

<http://sonin.mn/?p=125608>



Тэдний дундаас УИХ-ын гишүүн О. Чулуунбаттай хийсэн ярилцлага хүмүүсийн бухимдлыг хамгийн их төрүүлсэн. Үнэндээ сэтгүүлчийн байр суурь тодорхойгүй байсан ба харин УИХ-ын гишүүн маань Монголчуудыгаа басамжилж, мэдээжийн зүйл дээр худал ярьж олон нийтийн дургүйцлийг хөдөлгөснийг түүний өгсөн ярилцлагын доорхи сэтгэгдлээс харж болно.

<http://mongolnews.mn/i/17931>

Олон нийт хэрхэн хүлээж аваа?

Цөмийн хаягдал булшлах асуудлыг олон нийт нэлээд цочир хүлээж авч, дийлэнхдээ эсэргүүцсэн. Түүнчлэн хүмүүсийн мэдлэг мэдээлэл тэр бүр хангалтгүй нь анзаарагдаж байв. Тухайлбал, цөмийн түлшний хаягдал нь ураны олборлолт, боловсруулалт, хэрэглээний явцад гардаг хог хаягдал дотроос хамгийн ХОРТОЙ, хэдэн арван мянган жил болж задардаг, мөн дахин боловсруулах боломжгүй гэдгийг сайн мэддэггүйн улмаас тул зарим уншигчид цөмийн хогоо зүгээр өгөөд бас дээрээс нь мөнгө өгч байгаа бол авчихъя, дараа хэрэг болох биз гэсэн гэнэн санаа цухалзуулж байсан.

Монголчууд мэдээллийг хэрхэн хэрхэн хүлээж авсныг сонирхож судалж үзсэнээ та бүхэнд танилцуулья. Интернет дээр тавьсан орчуулгын мэдээний дор үлдээсэн санал сэтгэгдлийг дараахь бүлэгүүдэд хувааж үзсэн юм (sonin.mn, news.mn, mongolnews.mn дээрх сэтгэгдлээс авав).

1. Монголд цөмийн цацраг идэвхитэй хаягдлыг хаяхыг эсэргүүцсэн хүмүүс.

Тэдний дунд “УИХ гишууд минь ээ, та бүхний ач зээ хүүхдүүд чинь энэ нутагт л амьдарна шуу дээ, яагаад зөвхөн өнөө маргаашийн ашгаа харж байнаа. УИХ гишууд та бүхэн гадаадаас авилгал авсан аваагүй насаараа идэх хөрөнгөтэй шүү дээ Монголдоо ганц ч болов хэрэгтэй зүйл хий л дээ” гэж аргадаж гуйсан, “Монгол улс уранаар хөөцөлдөх хэрэггүй, ашигт малтмалаас өөр аргаар хөгжих аргаа сүвэгчлэх хэрэгтэй” эсвэл “ураныг зөвхөн олборлож, гадаадад борлуулахаас өөрөөр одоохондоо оролцох хэрэггүй” гэж зөвлөсөн, мөн Монголын улс төрчдөд итгэх итгэж алдарснаа илэрхийлж “Монгол улс төрийн тэргүүнээсээ эхлэн жирийн албан хаагч хүртэл авилгалд идэгдсэн тул гадаадынхан монголчуудад хэдэн цаасан ногоон мөнгө аманд нь чихвэл юуг ч хийж болно гэдэгт итгэж байгаа учир ийм юм ярьж хийж байгаа” гээд “айхтар юм болох нь дээ, үнэн байлаа ч бид тэднийг хориглох боломжгүй, тэд үүнийгээ нуухын тул юу ч хамаагүй хийх байх магадгүй бүр улайм цайм зүтгэх болов уу даа” гэж зовнисон, бүр ийм шийдвэр гаргавал “эсэргүүцэн босно, 7 сарын 1-нийг давтана” хэмээн сүрдүүлсэн сэтгэгдлүүд байлаа.

Түүнчлэн зарим сэтгэгдэлд ЗГ, УИХ-ын гишүүд болон тойрон хүрээлэгчид гадаадад дүрвэхээр бэлтгэж байгаа тухай мэдээлж, “200 гаруй өрх айл цаашид Канадад амьдрах асуудлаа хөөцөлдөөд эхэлчихсэн шүү. Тэд Монголд ан хийх гэж л ирнэ Харин бид үүрд амьдарна шүү дээ ард түмэн минь”, “Ерөнхий сайд Батболдын хийж байгаа ажил... Ямар нэг юм боллоо гэхэд өөрөө зугтаад л Англид очоод хэвтчих хүн. Тэнд байшин сав худалдаж авчихсан, суурьшихад бэлэн байгаа хүн” гэж бичсэн байлаа.

2. Дээрхээс тэс өөр бодолтой, Монгол улс нутагтаа цөмийн хаягдал хадгалах нь харин ч бүх талын оновчтой арга шийдэл гэж үздэг цөөн хэдэн хүмүүс.

“Зүгээр мөнгийг нь аваад говьд аваачаад булчихья, тэр элсийг юунд нь хайрладаг юм”, “угаасаа эх дэлхий биднээс болж бус дэлхийн өөрчлөлтөөр сөнөнө, айл ч олддоггүй төөрөөд байдаг асар уудам газарт булсан ч яадаг юм, бид нар үүгээр далимдуулж цөмийн байгууламж, тусгаар тогтнолоо хадгалж болно” гээд “хэзээ нэг цагт хаягдлаас эрчим үүсгэх шинэ технологи гарчих ч юм билүү” гээд “зүгээр өгч байвал аваад байя” гэж хүртэл уриалж үзэж байсан.

3. Мэдлэг боловсрол дутмаг болоод уу эсвэл зориудаар, өөр бусад шалтгааны улмаас ч тэр үү Монголд цөмийн хаягдал хаях хэлэлцээр явагдаж байгаа мэдээллийг худал цуурхал гэж бодсон, итгэхээс татгалзсан хүмүүс. Тэдний

дотор Монгол ард түмнийг “тэнгэр нь хаячихгүй байлгүй” гэж тэнгэр бурхан, эцэг өвгөдийн сүнс, төр засаг, 21-р зууны манлайлагч гүрэн АНУ болон хоёр хөршдөө хувь заяагаа даатгасан, гэнэн томоогүй, эсвэл хэт хүлцэнгүй, хэнэггүй ч гэмээр нэг хэсэг байх. Тэдний сэтгэгдэлд “Төр засгийг удирдаж байгаа хүмүүс арай ийм тэнэг зүйл хийхгүй биз дээ”, “бид зөвшөөрдөг юм гэхэд энэ 2 тал байгаа хөршүүд дуугарах байлгүй дээ”, “Манай дарга нар ийм тэнэг юм хийхгүй, эхлээд ард түмнээсээ асууж байж болох байлгүй дээ” гэж таамаглаж байв.

Мөн хэвлэлд үл итгэсэн, бусдыгаа хардаж сэрдэх сэтгэл хүчтэй хөгжсөн бас нэг хэсэг байх. Тэдгээр хүмүүс нийтлэгдсэн мэдээг хагас дутуу уншаад “итгэхгүй” хэмээн гэдийж, эх сурвалжийг бэлэн дурдсаныг үл тоомсорлон “хаанаас авснаа дурдах хэрэгтэй, баримт нотолгоотой зүйл уншмаар байна” гээд, зарим нь цөмийн хог хаягдлыг цөмийн зэвсгээр хөөцөлдөхтэй эндүүрч, “цөмийн хог хаягдлыг огт гаргахгүй байх хэрэгтэй” хэмээн цэцэрхэж, эцэст нь “Энэ бол огт худал. Нөгөө Ногоон намаа булаацалдаад байгаа нөхдүүдийн анхаарал татахын тулд хийсэн ажил байна, нөгөө мундаг BBC, CNN ч мэдээлээгүй байхад” гэж томорч байв.

Эрх баригчид хэрхэн хүлээж авав?

Эрх баригчид мэдээллийг үгүйсгэн мэлзсэн. Тухайн үед Цөмийн Энергийн газар, Засгийн Газар удаа дараа хаалттай хуралдаж, Гадаад Хэргийн сайд Г. Занданшатар нууц мэдээлэл хийж байсан тухай цухас дурдагдаж байсан. Мөн УИХ-ын гишүүн О. Чулуунбат “цөмийн хаягдлыг хоргүй” гэсэн ярилцлага өгч хүртэл үзсэн. Ингээд удалгүй Цөмийн Энергийн Газраас “тайван амгалан байцгаа, энэ бол огт худал мэдээлэл” гэсэн утгатай мэдэгдэл гаргаж байв. Мөн АНУ-ын ЭСЯ-ны мэдэгдлийг “Өнөөдөр” сонин нийтлэхдээ санамсаргүй эсвэл санамсартай алдаж орчуулснаар эхний үе өндөрлөж, хүмүүс цөмийн хаягдлын түгшүүрээ мартагнаж эхэлсэн билээ.


http://www.dailynews.mn/?vfile=7&vmet_id=18274&vmet_main=6470&vdate=&vl=archive

<http://politics.news.mn/content/63311.shtml>

<http://economy.news.mn/content/61381.shtml>

<http://mongolnews.mn/i/18087>

II. УДААХЬ ҮЕ



5 сарын 8-нд Японы өдөр тутмын Майничи сонины сурвалжлагч Айкава Харююки цөмийн хаягдлыг Монголд булшлахаар АНУ, Япон, Монгол гурав нууцаар хэлэлцэж буйг илчлэн бичсэнээр Монголын нийгэм сэргэж, асуудал анхаарлын төвд дахин орж ирсэн юм (ёстой л нөгөө “үнэнээр явбал үхэр тэрэг туулай гүйцнэ” гэдэг болж байх шиг). Майничи сонины мэдээллийг дэлхий нийтээрээ өлгөн авч нийтлэсэн тул Монголчууд цаашид ч нүдэн балай, чихэн дүлий суух аргагүй болсон билээ.



Түүнчлэн манай төрийн түшээд гадаад орнуудад цөмийн энерги, ураны асуудлаар гэрээ хэлэлцээр хийж байсан тухай мэдээ гарсны дотор Гадаад Хэргийн Тусгай Үүрэг Гүйцэтгэгч Элчин сайд А. Ундраагийн нөхөр нь Монголын төрийг төлөөлөн хувийнхаа MNFCC компанийн нэрээр Япончуудтай ураны гэрээ байгуулалцаж явсан бизнес илэрч нэлээд шуугиулсан.

<http://mongolnews.mn/i/19071>

<http://world.news.mn/content/65962.shtml>

<http://golomt.org/2011/05/10/nuclearbusiness/#more-1204>

Хэвлэл мэдээллийнхэн хэрхэн хүлээж авав?



Энэ удаад манай сэтгүүлчид хүмүүст мэдээллийг хүргэхээр шуурхай ажилласан. Тухайлбал, “Өдрийн Сонины” сэтгүүлч Долзодмаа Майничи сонины сурвалжлагчтай холбогдож мэдээллийг тодруулахаар ярилцсан нь чухал ач холбогдолтой алхам болсон билээ. Түүнчлэн, 25-р сувгийнхан цөмийн хаягдлын асуудлаар нэвтрүүлэг бэлтгэж, “Зууны Мэдээ” сонины сурвалжлагч нийтлэл бичиж хэвлүүлсэн. Харамсалтай нь зарим сэтгүүлчид миний олон хоногийн хөдөлмөрийн үр дүн болох Цөмийн хаягдал цуврал нийтлэлээс үг үсэг гээлгүй хуулбарлачихаад эх сурвалжийг нь дурьдалгүйгээр өөрийн нэрээр гаргаж байсан нь тоогүй санагдаж байсан билээ. Харин sonin.mn сайтынхан golomt.org дээрээс эдгээр цувралуудыг авч нийтлэхдээ эх сурвалжийг дурьдаж олны хүртээл болгож байсан нь соёлтой, ёс зүйтэй сэтгүүл зүйн жишээ болсон юм.

<http://www.dailynews.mn/publish/?user=5ryv59g8i197&vpage=1&vt=item>

<http://sonin.mn/?p=133094>

Энд хэвлэл мэдээллийнхэн тодорхой хэмжээгээр эрх баригчдын дарамтанд байдгийг гэрчлэх зарим нэг зүйл ажиглагдсан. Тухайлбал, **Монголд цөмийн хаягдал булаход бэлэн болжээ. Засгийн газар биднийг мэхэлж байна...** гэдэг бичлэгт нэр бүхий 7 хүнийг дурьдсан байсан юм. Sonin.mn бичлэгийг нийтлэснийхээ дараахан Г. Занданшатарын зургийг нэртэй нь авсан байсан. Ингээд хэд хоносны дараа зургийг эргүүлэн тавьсан билээ.

<http://sonin.mn/?p=132834>



Харин news.mn, shuud.mn зэрэг мэдээллийн сайтууд цөмийн хаягдлын талаар амаа үдүүлсэн мэт чимээгүй байлаа. News.mn дээр Майничи сонины мэдээллийг үгүйсгэсэн шинжтэй товч мэдээ гарсны дараахан сэтгүүлч З.Борбилмаа Цөмийн хаягдлыг Орос, Хятад сенсаацлаад байна уу? гэсэн нэртэй нийтлэл бичсэн нь Засгийн Газар эвгүй байдлаас гарах гарц эрэлхийлж, олныг туршсан болхидуу оролдлого юм уу гэж бодогдсон.

Хоёр хөршөө Монголд цөмийн хаягдал хадгална гэсэн худал мэдээлэл цацаж байна хэмээн үндэслэлгүйгээр буруутгасан(санаж байгаа бол анх мэдээлэл гарсан Global Security Newswire бол АНУ-ынх, харин Майничи сонин бол Японых) тус нийтлэлд хэд хэдэн алдаатай мэдээ, дүгнэлт байснаас заримыг дор товч тайлбарлав.<http://www.news.mn/content/66460.shtml>

Цөмийн түлшний хаягдал бол **ДЭЭД зэргийн хортой**, дэлхийн улс орнууд **үнэт түүхий эд** бус харин аюултай хаягдал гэж үздэг талаар цөмийн цуврал нийтлэлд дэлгэрэнгүй бичсэн байгаа. Товчхондоо бол цөмийн энерги ашигладаг дэлхийн улс орнуудын хувьд:

Цөмийн түлшний хаягдал бол **ДЭЭД зэргийн хортой**, дэлхийн улс орнууд **үнэт түүхий эд бус** харин аюултай хаягдал гэж үздэг (энэ тухай Цөмийн хаягдал цувралд дэлгэрэнгүй тайлбарласан). Товчхондоо бол цөмийн энерги ашигладаг дэлхийн улс орнуудын хувьд:

- 1) Цөмийн түлшний хаягдлыг дахин боловсруулснаас **хаяж булшилсан нь хавьгүй хямд** тусдаг. Дахин боловсруулж түлш үйлдвэрлэхэд өртөг зардал нь нэмэгдэж, цөмийн энерги хямд байхаа больдог.

- 2) ОХУ-д бүр социализмын үеэс уламжилж ирсэн, дээрээс нь Франц, Герман, Их Британиас нууцаар зөөж оруулсантайгаа нийлээд дор хаяж **700 мянган тонн цөмийн хаягдал бий**. Түүнийгээ дахин боловсруулах хүчин чадал, технологи, зардал мөнгө байхгүй тул Кольский хойг, Новая Земля, Владивосток зүг рүү хүн багатай нутгуудад газрын гүнд булшилж ирсэн түүхтэй.

- 3) **Цөмийн хаягдлыг дахин боловсруулах боловсронгуй технологи одоохондоо алга**. Breeder маягийн реакторууд нь маш осолтой, өртөг өндөртэй тул өнөөдөр хуруу дарам цөөхөн оронд үйл ажиллагаа явуулж байна.

- 4) **ОХУ нь бусдын түлшний хаягдлыг эргүүлж авахгүй гэсэн бодлоготой**. Тэд түлшний банк гэгчийг Ангарскт байгуулаад, тэндээс түлш худалдаж авсан тохиолдолд хаягдлыг нь буцааж авна гэсэн нөхцөлтэйгээр гадаад орнуудад борлуулж байгаа.

Олон нийт хэрхэн хүлээж аваа?

Сэтгэгдлээс харахад олон нийт асуудлыг илүү сонирхож, энэ талаар илүү ихийг мэдэхийг хүссэн шинжтэй байсан бөгөөд нутагтаа булахыг уриалсан, эргэлзсэн хүмүүсийн тоо эрс багассан нь ажиглагдсан. Иргэний хөдөлгөөнийхөн идэвхжиж эхэлснийг Ногооныхны хийсэн хэвлэлийн хурал, мөн түүнчлэн О.Бум-Ялагч Японы ЭСЯ-ны гадаа эсэргүүцэл илэрхийлсэн зэргээс харагдаж байв. Дийлэнх нь асуудлын голыг ойлгон, эсэргүүцэж байсны зэрэгцээ боловсролтой, мэдээлэлд анализ хийх чадвартай хүмүүс асуудлыг нарийн ухаж ойлгосон нь мэдрэгдэж байсан.

Эрх баригчид яав?

Монголд цөмийн хаягдал булшлах талаар албан бус яриа хэлэлцээр хийгдсэн гэдгийг гадна дотны олон эх сурвалж нотлосоор байсан ч эрх баригчид хүлээн зөвшөөрөхгүй, үгүйсгэсэн хэвээр. Тэдний баримталж буй бодлогыг З. Боргилмаагийн нийтлэлийн дор бичсэн нэгэн сэтгэгдэл бичигч тун оновчтой дүгнэн тайлбарласныг бага зэрэг засвартайгаар хүргэе:

1. **“Муу л бол захын хар овоохой”** массын сэтгэл зүйг ашиглан **бурууг Н. Энхбаяр гэх мэтийн хаа хамаагүй хүмүүс рүү чихээд** хэргийн эзэд өөрсдөө ард нь үлдэх гэж хичээж байна
2. Бас муу л бол нөгөө Хятад л байдаг гэсэн Хятадад дургүй массын сэтгэлзүй дээр бас тоглож, **“энэ бол Хятадуудын явууллага”** гэх мэтээр сурталчилж эхэллээ.
3. **“Цөмийн хог хаягдлыг Монголд булшлах нь ашигтай”** гэсэн хуурамч мессеж масст хүргэх санааг илт цухалзуулж эхэлсэн байна
4. **Энэ бизнесийг олон жилийн өмнөөс манай улс төрчид өөр өөрийн эрх мэдэлтэй дээрээ л хийх** гэж хамаг байдгаа шавхаж байгаа
5. Манай улс төрчид хэвлэл мэдээллээр өөрсдийнхөө болоод гэр бүлийнхээ тухай сөрөг мэдээ цацуулах дургүй. Тиймээс сонгууль болох гэж байгаа энэ үед хүмүүст **“энэ бол сөрөг талын сонгуулийн сурталчилгаа”** гэж ойлгуулахаар хичээж байна.

<http://www.news.mn/content/66460.shtml>

Эрх мэдэлтнүүд энэ талаар дуугарсан, бичсэн хүмүүсийг сүрдүүлэх, дарамтлах, баривчлах, Мөрдөн байцаах газар дуудаж дуугүй байхыг сануулах зэрэг арга хэмжээ удаа дараа авч байна. Ганц жишээ татахад, саяхны нэг өдөр Б. Хурцыг суллахыг шаардаж Английн ЭСЯ-ны өмнө жагсаж, чанга дуугаар хашгирч, өндөг, улаан лооль шидсэн жагсагчдыг яагаа ч үгүй мөртлөө Японы ЭСЯ-ны өмнө Монгол цөмийн хаягдал хаях асуудлаар эсэргүүцлээ илэрхийлж “Японы Элчин сайд аа, Монгол Улс цөмийн хог хаягдлын нутаг биш” гэж англи, монгол хэлээр бичсэнээ барьж зогссон О. Бум-Ялагчийг цагдаа баривчилж байх юм.

http://www.dailynews.mn/?vfile=7&vmet_id=19107&vmet_main=6856

<http://www.mongolnews.mn/i/19145>

<http://sonin.mn/?p=134869>

Санаж явахад илүүдэхгүй сургамж

Миний бие энэ хугацаанд гар хумхиж суусангүй. Монголын сэтгүүлчид цөмийн эрчим хүч ашиглалт, цөмийн хаягдлын хор хөнөөл, олон улсын бодлого, туршлагын талаар олон нийтэд үнэн зөв мэдээлэл хүргэх тал дээр хангалтгүй ажиллаж байсан тул тэдний дутуу үлдээсэн ажлыг нөхөхөөр сэтгэл шулуудан цөмийн хаягдлын талаар 3 цуврал, хэд хэдэн нийтлэл бичсэнийг golomt.org дээр нийтэлсэн.

•Цөмийн хаягдал цуврал-1: **Монголд цөмийн хаягдал булшлах уу?**

<http://golomt.org/1056-2/>

•Цөмийн хаягдал цуврал-2: **Монголд АТОМ хэрэгтэй юу?**

<http://golomt.org/2011/04/26/nukes2/#more-1115>

•Цөмийн хаягдал цуврал-3: **Бусад орнууд цөмийн хаягдлаа хаана хаядаг вэ буюу яагаад Монголд булшлах болов?** <http://golomt.org>

Монгол улс АЦС барихаар шулуудаж, цөмийн аюул аминд тулж ирсэн өнөө үед Монгол хүн бүр цөмийн энерги, цацраг идэвхит бодисны талаар доорхи зүйлийг мэдэж, оюун ухаандаа тунгаан бодох нь **ЗҮЙТЭЙ** болов уу:

1) Уран олборлох, боловсруулах, түлш үйлдвэрлэх, АЦС- дээр цөмийн энерги үйлдвэрлэх гээд **үе шат болгонд ЦӨМИЙН ХОРТ ХАЯГДАЛ** гарна. Огт хаягдалгүй үйл явц гэж үгүй. Эдгээрээс **цөмийн хаягдал түлшний ХОР ХӨНӨӨЛ** хамгийн аюултай. Учир нь эрчим хүч үйлдвэрлэх явцад түлшин дэх ураны 10 хүрэхгүй хувийг л ашигладаг, харин цөмийн урвалд орж асар идэвхжсэн үлдэгдэл ураныг хаягдал хэмээдэг. **Хүн хөндөөгүй байгальдаа байхдаа л уран хамгийн аюул багатай.** Харин хөндөж эхлэмэгц улам бүр хүчирхэг хор хөнөөлийг агуулсан зэвсэг болж хувирдаг.

2) **Цөмийн түлшний хаягдал бол ҮНЭТ түүхий эд бишээ.** Түүнийг дахин боловсруулах аюулгүй технологи дэлхийд **огт байхгүй.** “Тэр бүү хэл ирэх 50 жилд ч гарахгүй” гэсэн АНУ-ын өндөр мэргэжлийн хүний лекцэнд би саяхан суусан билээ. Бусад эх сурвалжууд ч үүнийг баталж байна. Өнөөдөр дэлхий даяараа эрчим хүчний аюулгүй эх сурвалжийг эрчимтэй эрэлхийлж буй тул 50 жилийн дараа гэхэд АЦС ашиглалтаас гарах төлөвтэй. Тухайлбал, Герман, Япон цөмийн эрчим хүчнээс татгалзах үе шаттай бодлогоо боловсруулаад эхэлж байна. Итали улс гэхэд Чернобылийн ослын дараахан бүх нийтийн санал асуулга явуулаад АЦС ашиглахаа зогсоосон. Харин Монголчууд л АЦС барьж, өөрийн болон хүний хорт хаягдлыг булшлахаар тэмцэлдэж байна.

3) **Цөмийн түлшний хаягдлыг булшлах нь баталгаатай биш**, энэ асуудлыг шийдвэрлэсэн улс орон байхгүй аж. Хичнээн зузаан хайрцаг саванд хийж газрын гүнд булсан ч осол эндэл тохиолдох энүүхэнд. Тухайлбал, Берлинээс 225 км орших уурхайд 950 метрийн гүнд булсан цөмийн хаягдал хөрсөнд нэвчсэнийг илрүүлсэн германчууд асуудлыг шийдвэрлэхэд хүчин мөхөсдөж байна.

<http://ipsnews.net/news.asp?idnews=43108>

4) **ОХУ -ын “РосАтом” төрийн өмчит компани олон жилийн туршид ард түмнээ мэхлэн, хуулиа зөрчин байж баруун Европын орнуудын цөмийн хаягдлыг зөөж, нутагтаа хадгалж байна.** Тэд 2009 онд түүхий эд нэрээр Францын цөмийн хаягдлыг оруулж байснаа олон нийтийн шахалтаар зогсоолоо гэж албан ёсоор мэдэгдсэн ч 2010 онд нууцаар оруулж байгаад баригджээ. Түүнчлэн Францын Засгийн газар, түүнийг төлөөлсөн Арева (Eurodif) компани ч бас гэрээгээ цуцаллаа гэсэн нь худал байсан байна.

Дашрамд хэлэхэд, дээр нэр дурьдсан Арева компанитай Монголын засгийн газар ураны олборлолтын асуудлаар хамтран ажиллахаар гэрээ байгуулаад ажиллаад эхэлсэн билээ (Areva компани Нигерт уран олборлож газар нутаг, хүн ардыг нь цацраг идэвхит тоосонцорт асар ихээр хордуулж байгаа тухай Гринпис байгууллага судалсан ажээ. Areva компани ч үнэнийг хүлээн зөвшөөрсөн байна.

<http://www.greenpeace.org/international/en/news/Blogs/nuclear-reaction/left-in-the-dust-arevas-uranium-mining-in-nig/blog/11734>

Орост цөмийн хаягдлыг нутагтаа булшлах ажлыг төрийн өмчийн “РосАтом” компани нууцхан зохион байгуулж, эрх мэдэлтнүүд нь асар их мөнгө завшсан.. Монголд тэгвэл төрийн өмчийн “МонАтом” компани ажлаа эхэлжээ.

Түүх давтагддаг. Гуч гаруй жилийн турш ард түмнээ мэхлэн байж нутагтаа цөмийн хаягдал булшилсан Оросын эмгэнэлт түүх Монголд давтагдаж байна.

Монголчууд бид “Үлдэх хүнээр ачаа бүү татуул” гэдэг билээ. Тэгвэл явуулын хүнд улс эх орныхоо ирээдүй хойчийг даатгаж суух нь зөв гэж үү? АНУ-ын ногоон карт хэмээн байнгын оршин суух эрх эзэмшдэг А. Ундраа эх нутагт минь АЦС бариулж, хүний өөрийн хорт хаягдал булахаар тохирчихоод харь холд одохоор зэхэж сууна. Нэгэнт харьд бие сэтгэлээ тушаасан хүнээр төрийн чухал алба хашуулж, улс орныхоо ирээдүйг шийдүүлээд бид чинь чухам юу л болж байна даа?



**“Монгол улс хүссэн ч хүсээгүй ч гадны цөмийн хаягдал була
л болно”** гэж Гадаад Хэргийн Тусгай Үүрэг Гүйцэтгэгч Элчин сайд А. Ундраа
саяхны нэг өдөр Мөрдөн байцаах газар дуудагдсан О. Бум-Ялагчид
мэдэгдснийг О. Бум Ялагч бидэнтэй холбогдож дамжуулсан билээ.

<http://sonin.mn/?p=134869>